

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2021 ОНЫ 05 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 05 дугаар сарын 31-ний өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, МУЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1.11.3, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2 дахь заалтын хүрээнд паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгааны хэсгийг баталгаажуулах явцад хяналт тавьж байна. - Паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугам болон үндсэн дэд станц болох 110/35кВ-ын зураг төсөл, паркийн үндсэн 110/35кВ-ын дэд станцаас Хүнд үйлдвэрлэлийн бүсэд байгуулагдах цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 35кВ-ын агаарын шугам болон 35/10кВ-ын төмөрлөг дэд станцын зураг төсөл ЭХЯ-ны Эрчим хүчний хөгжлийн төвийн магадлангаар хянагдан баталгаажсан. - 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдөр дээрх зураг төслийн төсвийг ЭХЯ-ны Эрчим хүчний хөгжлийн төвийн төсвийн магадлангаар хянуулахаар хүргүүлсэн. 	100%
2.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.5	<ul style="list-style-type: none"> - Парк инновацич байгууллага болох зорилгоор ШУ-ны үндэслэлтэй, батлагдсан технологи бүхий төслүүдэд судалгаа хийж, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. - Бор-Өндөр Мандал ХХК-аас ирүүлсэн хайлуур жонш, нүүрс, төмөр, каолин, цахиур зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах, баяжуулах аж үйлдвэрүүдийн төслүүдийг судалж танилцсан. 	100%
3.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3.1	<ul style="list-style-type: none"> - НЗДТГ-ын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 01/1868, НШУУИГ-ын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 02/151 дугаартай дугаартай албан бичгийн дагуу “Нийслэлийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө”-ний төсөлд тусгуулах саналыг боловсруулан "Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк" ОНӨТҮГ-ын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 65 дугаартай албан бичгээр НШУУИГ-т, amartuvshin.sidia@gmail.com цахим хаягт, мөн өдрийн 66 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, sanal.hbth@gmail.com цахим хаягт тус тус хүргүүлсэн. 	100%

		- Паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын нарийвчилсан тооцооллыг Сангийн яамны холбогдох мэргэжилтний ERP цахим хаягт хүргүүлсэн.	
4.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3.3	Монхимо ХХК-ий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар сурталчилгааны материалыг шинэчлэн Цахим хуудсанд байршуулсан.	100%
5.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.3.1	Зүүн бүсийн аймгуудын удирдлагатай харилцаа холбоо тогтоож, Паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчлах, санамж бичиг байгуулах үүднээс Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 71, 72, 73 дугаартай хамтран ажиллах тухай албан бичгийг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн.	100%
6.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.1.1	Паркийн хөрөнгө оруулалтын саналуудыг шинэчлэн байгууллагын цахим хуудсаар дамжуулан сонирхогч иргэн, хуулийн этгээдэд хүргэж байна.	100%
7.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	- 2021 оны 05 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хариутай 10, хариугүй 5 нийт 1 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.73 - 2021 оны 05 дугаар сарын байдлаар "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 14 хариугүй бичиг явуулсан. Шийдвэрлэлт-100%	100%
8.	ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол	- 2021 оны 05 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 5, цар тахалтай холбоотой 12 мэдээллийг байршуулсан.	100%
9.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	- www.shilendans.mn сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна. - 2021 оны байгууллагын батлагдсан төсвийн хуваарийн дагуу 5 дугаар сарын санхүүгийн орлого зарлагын гүйлгээг хугацаанд нь зохих журмын дагуу хийлгэсэн.	100%
10.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.1	- Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. - Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна. - Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг зааврын дагуу хэвлэн иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна. - Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 398 дугаартай албан бичгийн дагуу танилцуулга видео контентыг байгууллагын вэб сайт болон олон нийтийн сүлжээнд байршуулах ажлыг 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. - "Ковид 19 эрсдэл систем"-ийг бүх албан хаагчдад гар утсандаа суулган ашиглаж байна.	100%

	<p>Нийслэлийн Засаг даргын А/357 дугаар захирамжийн дагуу дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - “Коронавируст халдвар тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам” өөрчлөн батлагдсантай холбогдуулан байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан таниулж байна. - Бүх албан хаагчид коронавируст халдварын эхний тунд хамрагдсан. - ЭМЯ-наас тогтоосон хуваарийн дагуу албан хаагчид дархлаажуулалтын 2 дахь тунд хамрагдаж байна. 	
НЭМЭЛТ АЖИЛ		
11.	НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 7 хоног тутам НЗДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хүргүүлэн ажиллаж байна.	100%
12.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна.	100%
13.	2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн байгууллагад коронавирусын халдвар бүртгэгдсэн эсэх судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж, 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдрүүдэд мэдээг шинэчлэн НЗДТГ-ын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP чатад хүргүүлэн ажиллаж байна.	100%
14.	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 115, 118 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/357 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
15.	Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/114 дүгээр захирамжийн дагуу Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заагдсанаар мөнгөн хандивыг цуглуулж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан тухай мэдээг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 63 дугаартай албан бичгээр дүүргийн ЗАА-нд хүргүүлсэн.	100%
16.	МУИС-аас 04 дүгээр сарын 23-ны өдөр ирүүлсэн 8/101 дугаартай албан бичгийн дагуу 2017-2020 онд шинжлэх ухаан технологийн чиглэлээр гүйцэтгэсэн арга хэмжээний санхүүгийн зардлын судалгааг гаргаж www.survey.openscience.mn сайтад 05 дугаар сарын 10-ны өдөр мэдээллийг оруулсан.	100%
17.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дэвшүүлсэн “ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ” зорилтын хүрээнд “ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ХАМТДАА ХӨДӨЛМӨРИЙН ЦАХИМ ЯАРМАГ-2021” арга хэмжээг www.expomongolia.org/careerexpo платформоор дамжуулан 2021.05.08-2021.05.24-ний хугацаанд зохион байгуулахтай холбогдуулан ажил хайгч иргэдийг өргөнөөр оролцохыг уриалан мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	100%
18.	НЗДТГ-ын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 02-02/1950 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн хүрээнд Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний 17-д заасны дагуу байгууллагын дэргэд Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулах, тэргүүн сонгох, дүрэм батлах асуудлыг байгууллагын хамт олны хурлаар хэлэлцэн, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/10	100%

	дугаар тушаалаар баталж, Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулсан тухай илтгэх хуудсыг 05 дугаар сарын 21-ний өдрийн 69 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.	
19.	<ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу байгууллага хамт олноороо "Монгол бичигтэн болцгооё" аяныг 5 дугаар сард өрнүүлж, албан хаагчид цахим орчинг ашиглан монгол бичгийн анхан шатны мэдлэгийг бие даан судалсан. - Монгол бичгийн анхан шатны 10 асуулт бүхий тестийг боловсруулж, 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр бүх албан хаагчдаас тест авахад ажилтнууд 1-2 алдаж нийт дунджаар 82%-ийн үзүүлэлттэй гарсан. 	100%
20.	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/01 дүгээр тушаал, дүүргийн Засаг даргын 2018 оны А/194 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Бүх нийтээрээ цэвэрлэгээнд нэгдье" уриатай Ногоон бүсийн цэвэрлэгээг хуваарьт газарт зохион байгуулж, тайланг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 75 дугаартай албан бичгээр дүүргийн ЗАА-нд, baganuurzaa@gmail.com цахим хаягт тус тус хүргүүлсэн.	100%

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА

